

## УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

.....оны ... сарын ..... өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Түлшний бодлогын газар /Ч.Чuluунбат/, Ашигт малтмал, газрын тосны газар /Б.Баатарцогт/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хуулийн хэлтэс /С.Мандахбат/, Түлшний бодлогын газар /Ч.Чuluунбат/-т тус тус даалгасугай.

САЙД

Ц.ДАШДОРЖ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны  
..... дугаар сарын ....ны өдрийн  
.....дугаар тушаалын хавсралт

Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын,  
ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам

### **Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг үндэслэн газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 “Газрын тосны тухай” хууль болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актад заасан үндэслэлээр газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг Засгийн газар /ЗГ/-т гэрээлэгч буцаан өгөх, ЗГ гэрээлэгчээс хүлээн авахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.3 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг хэсэгчилэн болон бүхэлд нь буцааж болно.
- 1.4 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутгийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн эрлийн талбайг бүхэлд нь, БХГ-т хайгуулын талбайн хайгуулын ажил хийгдээгүй хэсгийггэрээт талбайгаас хасалт хийж протокол үйлдэж хэсэгчилэн буцаан авч болно.

### **Хоёр. Талбайг хэсэгчилэн болон бүхэлд нь буцаах тухай хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичиг**

- 2.1 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг хэсэгчилэн болон бүхэлд буцаах тохиолдолд дараахь материалыг бүрдүүлэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Үүнд:
  - Тухайн талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаах тухай албан ёсны хүсэлт, тайлбар. (Холбогдох зураг материал)
  - Тухайн талбайд гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан. (Холбогдох зураг материал)
  - БХГ-ний хэрэгжилт. (Он оноор)
  - Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан.
  - Жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээх ажлын тайлан.
  - Жил бүрийн орчны хяналт шинжилгээний ажлын тайлан.
  - Буцаагдаж буй талбайд хийсэн газрын хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлт.
  - Буцаагдаж буй талбайд өрөмдсөн цооногийн нөхөн сэргээлт хийсэн талбайгаас хөрсний дээж авч “Хөрсний чанарын стандартын” дагуу итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэсэн ажлын тайлан, дүгнэлт.

- Нөхөн сэргээлт хийсэн талбайг орон нутагт хүлээлгэн өгсөн баримт материал.
- Монгол улсын хууль хяналтын байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, түүний хэргэжилт.
- Ажлын хэсэг нь шаардлагатай тохиолдолд гэрээлэгчээс нэмэлт мэдээлэл гаргуулах эрхтэй.
- Ажлын хэсэгт ирүүлсэн тайлан, материал шаардлага хангаагүй тохиолдолд тайлан, материалыг шаардлага хангуулахаар буцаах эрхтэй.

## **Гурав . Үнэлэлт, дүгнэлт гаргах**

- 3.1. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага талбай буцаах тухай хүсэлтийг гэрээлэгчээс хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор Байгаль орчныг хамгаалах төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн байгууллагатай хамтран талбай буцаан авахад дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулна.
- 3.2. Ажлын хэсгийн хурлыг ажлын хэсгийн дарга удирдах ба түүний эзгүй эрх олгосон гишүүн хурлыг удирдаж болно.
- 3.3. Хурлын ирц 70 хувиас дээш тохиолдолд хурал хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 3.4. Ажлын хэсгийн хуралд хүрэлцэн ирээгүй гишүүн саналаа гарын үсэг зурж баталгаажуулан бичгээр ажлын хэсэгт ирүүлнэ.
- 3.5. Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш 14 хоногийн дотор ажлын нарийвчилсан төлөвлөгөөг батална.
- 3.6. Ажлын хэсэг, буцааж буй талбайг нөхөн сэргээсэн байдалтай төлөвлөгөөнд заасан хугацаанд газар дээр нь танилцаж, дүгнэлт гаргана.
- 3.7. Ажлын хэсгийн дүгнэлтээр тухайн талбайд хийсэн нөхөн сэргээлтийн ажил холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангаагүй тохиолдолд нөхөн сэргээлтийг гүйцээн хийлгэх тухай албан шаардлагыг ажлын 10 хоногт багтаан гэрээлэгчид хүргүүлнэ.
- 3.8. Гэрээлэгч ажлын хэсгээс хүргүүлсэн шаардлага, дүгнэлтийг хүлээн авсанаас хойш 60 хоногийн дотор шаардлагын биелэлтийг ажлын хэсэгт албан ёсоор танилцуулах ба ажлын хэсэг шаардлага, дүгнэлтийн биелэлтийг **20** хоногийн дотор газар дээр нь дахин шалгаж, дүгнэлт гаргана.
- 3.9. Ажлын хэсэг талбай хүлээж авах тухай нэгдсэн санал дүгнэлтээ дараагийн шатны холбогдох байгууллагуудад танилцуулан шийдвэр, дүгнэлт гаргуулна.

**Дөрөв. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл,  
хайгуулын үед буцаагдаж буй талбайд өрөмдсөн  
цооногийг хүлээлгэн өгөх**

- 4.1 Хий, хий агуулсан усны үе илэрсэн цооногийг бүхэлд нь эсвэл хэсэгчилэн цементэн хаалтаар цутгасан байна. Цементэн хаалт хийсэн үйл ажиллагааг баримтжуулсан байна.
- 4.2 Цооногийн амсарыг дараах байдлаар битүүмжилсэн байна.
  - а/ Бэлчээрийн талбайд орших цооногийн амсрыг эрээстэй төмөр таглаагаар эсвэл гагнаж битүүмжлэн, 0.5 м-с багагүй өндөртэй төмөр самбар дээр цооногийн дугаар, эрэл эсвэл хайгуулын талбайн нэр, дугаар, гэрээлэгчийн нэр, цооногийг хаасан огноо зэргийг гагнуураар бичиж, цооногийн амсрыг тойруулан 1x1x1м хэмжээтэй бетонон хашлага хийсэн байна.
  - б/ Газар тариалангийн талбайд орших цооногийн амсрыг газрын гадаргуугаас доош 2 метрээс багагүй гүнд эрээстэй зэвэрдэггүй металлаар таглаж эсвэл гагнаж битүүмжлэн булаад 0.5 м-с багагүй өндөртэй төмөр самбар дээр цооногийн дугаар, эрэл эсвэл хайгуулын талбайн нэр, дугаар, гэрээлэгчийн нэр, цооногийг хаасан огноо зэргийг гагнуураар бичиж байрлуулсан байна.
  - в/ Хайгуулын үед буцаагдаж байгаа талбайд орших бага ундаргатай, тосны илрэлтэй цооногуудыг хадгалалтанд зориулж хаахдаа перфораци хийсэн интервалаас дээш 50 метрээс багагүй зузаан цемент цутган, цооногийн дотоод тоноглолыг баримтжуулан хүлээлгэн өгнө.

**Тав. Буцаагдаж буй талбайн нөхөн сэргээлтийн ажлыг  
гүйцээн хийлгэх**

- 5.1. Ажлын хэсгийн дүгнэлтээр тухайн талбайд хийсэн нөхөн сэргээлтийн ажлууд нь холбогдох стандартын шаардлага хангаагүй бол нөхөн сэргээлтийг гүйцээн хийлгэнэ.
- 5.2. Талбайн нөхөн сэргээлтийг гүйцээн хийх нь тусгай зөвшөөрлийн төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх үндэслэл болохгүй.
- 5.3. Талбайн нөхөн сэргээлтийн нэмэлт зардлын хэмжээг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Гэрээлэгч харилцан тохиролцож, нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэд хийхэд шаардлагатай хэмжээгээр зардлыг тогтоох ба энэхүү зардлыг гэрээлэгч хариуцна.
- 5.4. Гэрээт талбайн нөхөн сэргээлтийг мэргэжлийн туслан гүйцэтгэгч байгууллагаар гүйцэтгүүлж болох ба гэрээлэгчээс хяналт тавин ажиллана.

## **Зургаа. Бусад**

- 6.1. Буцааж буй талбайг хүлээн авахад ашиг сонирхлын зөрчилтэй гишүүн байвал тухайн ажлыг үнэлэхээс татгалзана. Энэ тухайгаа ажлын хэсэгт мэдэгдэх үүрэгтэй.
- 6.2. Талбай буцаахаар хүсэлт гаргасан Гэрээлэгч нь байгаль орчны асуудлаар захиргааны болон эрүүгийн хэрэгт холбогдсон эсвэл байгаль орчны асуудлаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, гаргасан зөрчлөө засаагүй бол талбайг хүлээн авахаас татгалзана.
- 6.3. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын талбайн буцаагдаж буй хэсгээс газрын тос, уламжлалт бус газрын тосны цооногоос бусад барилга байгууламж, бараа материалыг бүрэн чөлөөлсөн байна.
- 6.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээний хугацаа дуусч, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах үйл ажиллагааг орд хаах, татан буулгалтын төлөвлөгөөгөөр зохицуулна.

-----оОо-----